



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/150

Батширээт сум

**Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны А/436 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээний нийт бог малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 22-ны өдрийн хүртэл 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч дархлаажуулалтад бүрэн хамруулж ажиллахыг нийт малчид, мал бүхий иргэдэд, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллах малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж хүн хүчээр хангаж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай

3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явцад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501293